Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дорж-Янжмаа Соёлмаа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1.1. Ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах							
1	"Цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль-хамгийн сайн сургууль" арга хэмжээг хэрэгжүүлэх судалгаа тооцоолол хийн, холбогдох баримт бичиг боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана.	Нийслэлийн цөөн хүүхэдтэй анги, стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн тооны хувь	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн хувь-нийслэл 76.5	Арга хэмжээг хэрэгжүүлэх тооцоолол, судалгаа хийгдсэн байна.	Боловсролын сайдын 2025 оны А/113 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан “бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль-хамгийн сайн сургууль" арга хэмжээг хэрэгжүүлэх, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүн амын төвлөрөл ихтэй хороолол, хотхонд бага сургууль байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд хүн амын төвлөрөл ихтэй, төрийн болон орон нутгийн өмчийн сургуульгүй хороолол, хотхон, бага ангийн суралцагчдын судалгаа,	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					түрээслэх иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа бага сургуулийн зориулалтаар ашиглах боломжтой барилга, эсхүл хороолол, хотхоны зохих стандарт, шаардлага хангасан орон сууцны барилгын нэг давхар, үйлчилгээний талбайн судалгааг хийсэн. Хотхоны бага сургууль байгуулах асуудлаар ажлын хэсэг 3 удаа хуралдсан. Ажлын хэсэг Боловсролын сайдын тушаалаар "Хотхоны бага сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийг боловсруулан батлуулахаар шийдвэрлэсэн. "Хотхоны бага сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийн төслийг боловсруулж газар, хэлтсийн дарга нар албан бичиг хэргийн системээр хянаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлийн хүн амын төвлөрөл ихтэй, төрийн болон орон нутгийн өмчийн сургуульгүй, хороолол хотхонд "Хотхоны бага сургууль" байгуулснаар бага ангийн суралцагчдыг гэрт ойр сургуульд нэг ээлжид хичээллэх боломж бүрдэж, бага ангийн бүлэг дүүргэлт багасна. Хавсралт: 3 файл		
2	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын унших суурь чадварыг нэмэгдүүлэх зорилгоор чөлөөт	шинээр байгуулагдсан бичил номын сангийн тоо	-	-	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын суурь унших чадварыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, насан туршийн суралцахуйн төв, нийслэлийн зарим	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	уншлагын бичил номын сан байгуулах талаар удирдамж, чиглэл боловсруулж хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана.				дүүргийн хороодын иргэний танхимд бичил номын сан байгуулах чиглэлээр судалж байна. Зарим хороодын иргэний танхимын байрыг очиж үзэн бичил номын санд тавих номын тавиур, сандал ширээ хийх зардлын тооцооллыг гаргасан. Мөн сургууль, дотуур байр, хороо хаана ч тавих боломжтой номын сангийн өөртөө үйлчлэх киоск, 24 цагаар өөртөө үйлчлэх ухаалаг номын сангийн шүүгээ зэргийг судалж Боловсролын ерөнхий газрын холбогдох мэргэжилтэн, дарга нартай уулзалт зохион байгуулж санал солилцсон. Бичил номын сан байгуулах ажил 2025 оны сүүлийн хагас жилд хийгдэнэ. Хавсралт: 3 файл	12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Ерөнхий боловсролын сурах бичгийг цахимжуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.	Ерөнхий боловсролын сургуулийн цахим сурах бичгийн тоо	-	33	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хэвлэмэл сурах бичгийг дижитал хэлбэрт хөрвүүлэх, сургалтад цахим сурах бичгийн систем турших ажлын хүрээнд 13,500 орчим интерактив дасгал, даалгаврын сантай, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн явц, үр дүнтэй холбоотой мэдээллийг цахим технологи ашиглан богино хугацаанд цуглуулах, багшийн ажлын ачааллыг бууруулах, арга зүйгээ төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх цогц цахим систем, боловсролын мэргэжлийн байгууллагын холбогдох хүний нөөц, ерөнхий боловсролын сургуулийн багш нар цахим арга хэрэгсэл, модуль ашиглан интерактив дасгал, даалгавар боловсруулах программ бүхий бага ангийн 1-5 дугаар	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ангийн 33 сурах бичгийн агуулга, дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлж Боловсролын ерөнхий газар хүлээн авсан. Тус цахим систем нь хичээлийн хуваарь, сурагчдын ирц, интерактив сурах бичгийн дасгал, даалгаврын гүйцэтгэл, цахим сурах бичгийн ашиглалттай холбоотой их өгөгдлийг сурагч, анги, бүлэг, сургууль, дүүрэг, аймаг, үндэсний түвшинд үүсгэх, дүн шинжилгээ хийх, хянах, сурах бичгийг интерактив хэлбэрт хөрвүүлэх, дасгал даалгаврыг хөгжүүлэх, шинээр зохиох тусгайлсан багаж, хэрэгсэлтэй тул сурах бичиг зохиогч, хөгжүүлэгч нар өөрсдөө интерактив сурах бичиг зохиох боломжтой. Боловсролын ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сард аймаг, нийслэлийн боловсролын газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд цахим сурах бичгийг ашиглах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Цахим сурах бичгийг https://e-sur.edu.mn/ цахим хуудсанд нээлттэй байршуулсан бөгөөд бага ангийн суралцагчид, багш нар байнга ашиглаж байна. Хавсралт: 4 файл		
4	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний шинэчилсэн бүртгэл, судалгаанд тулгуурлан авч хэрэгжүүлэх арга	Санал	-	Шинэчилсэн судалгааны үр дүнг нэгтгэн санал боловсруулсан байна.	Сургалтын хэрэглэгдэхүүний менежментийн платформ буюу Mlab 2.0 системээр 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хэрэглэгдэхүүний шинэчилсэн бүртгэлийг хийж 2025 оны 04 дүгээр сард дууссан. Багш нар хариуцдаг кабинет, заадаг хичээлийн	5-р сар, 6-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

	хэмжээний санал боловсруулна.				хэрэглэгдэхүүнийг бүртгэж сургуулийн сургалтын менежерүүд хянаж баталгаажуулан нийт төрийн болон орон нутгийн өмчийн 701 сургуулийн 1953 нэр төрлийн хэрэглэгдэхүүний бүртгэл, шаардлага хангасан эсэх мэдээллийг бүртгэлээ. Аймаг, сум, дүүрэг, сургууль бүрээр кабинет, лаборатори, хичээл бүрээр хэрэглэгдэхүүнийг бүртгэснээр судалгааны үр дүнд тулгуурлан хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой болгох боломжтой гэж үзэж байна. Хавсралт: 2 файл		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Орон нутгийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагад сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Цахим систем ашиглалтын хувь	Боловсролын яамнаас олгодог зөвшөөрлүүд цахимд шилжсэн	Аймаг, нийслэлийн ЗДТГ, БГ сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг хүлээн авч, цахим системийг ашиглаж эхэлсэн байна.	21 аймаг, нийслэлийн засаг дарга нарт албан бичиг хүргүүлж орон нутагт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах, зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт, бичиг баримтыг Зөвшөөрлийн цахим системээр хүлээн авч магадлан шалгах ажлын хэсгийн судалгааг нэгтгэн тус системийг хөгжүүлэгч байгууллага болох Санхүүгийн мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн. Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран аймаг, нийслэлийн боловсролын газар, аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга мэргэжилтнүүдэд 2025 оны 3, 4 дүгээр сард хоёр удаа цахим сургалт зохион байгуулсан. Цахим сургалтаар зөвшөөрлийг хэрхэн олгох болон Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Зөвшөөрлийн цахим системийг ашиглах талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс болон аймаг, нийслэлийн Боловсролын газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд онлайнаар болон утсаар байнга зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн Зөвшөөрлийн тухай хууль болон Боловсролын ерөнхий хуулийн зөвшөөрөл олгох сунгахтай холбоотой зохицуулалт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой мэдээлэл, зөвлөгөөг тасралтгүй өгч аймаг, нийслэлийн хэмжээнд системтэй холбоотой үүссэн асуудлыг Санхүүгийн мэдээллийн технологийн төвд уламжлан шийдвэрлүүллээ. Зөвшөөрлийн цахим систем буюу www.license.mn системд аймаг, нийслэлийн Боловсролын газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүд зөвшөөрөлтэй сургууль, цэцэрлэгүүдээ бүртгэж дуусгасан бөгөөд зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
6	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1, 7.3, 8.2 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэгт заасан зөвшөөрөл	Хүсэлт шийдвэрлэлтийн хувь	2023 онд шинээр олгосон зөвшөөрөл-9, сунгасан зөвшөөрөл-8	Цахим системээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг	Зөвшөөрлийн цахим системээр зөвшөөрөл сунгах болон шинээр авах 8 сургуулийн хүсэлтийг хүлээн авсан. Боловсролын сайдын 2025 оны А/159 дүгээр тушаалаар Мон-Алтиус дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын Мон-Алтиус сургуульд сургалтын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл, Боловсролын сайдын 2025	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	сунгах, шинээр авах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.			хүлээн авч шийдвэрлэсэн байна	оны А/56 дугаар тушаалаар ерөнхий боловсролын Номын ёс сургуульд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, Боловсролын сайдын 2025 оны А/256 дугаар тушаалаар МУБИС-ийн харьяа ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасан. Олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгах хүсэлт ирүүлсэн И Эс Эм олон улсын дунд сургууль, Орчлон сургууль, Сингапур скүүл оф Монголиа сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа Мандах лицей, Их засаг лицей сургуулийн зөвшөөрлийн хүсэлтийг ажлын хэсэг магадлан шалгаж байна. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг нэгтгэн тухай бүрд нь системээр сургуулиудад хүргүүлж, зөвшөөрөл олгох сунгахтай холбоотой болон систем ашиглахтай холбоотой зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.	сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Зөвшөөрлийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлж, зөвшөөрөлтэй сургуулиудын гэрчилгээг шинэчлэн олгоно	Зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосон байгууллагын нийт зөвшөөрөлтэй байгууллагад эзлэх хувь	-	Зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох байгууллагатай хамтран цахимжуулсан байна	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэг, 8.2 дугаар зүйлийн 6.3, 6.4 дахь хэсэгт заасан зөвшөөрөл авсан байгууллагуудыг Зөвшөөрлийн цахим санд бүрэн бүртгэсэн. Зөвшөөрөлтэй ерөнхий боловсролын сургуулиуд Зөвшөөрлийн цахим сангаас qr код бүхий тусгай болон энгийн зөвшөөрлийн лавлагаа тодорхойлолтыг хэвлэн авч ашиглаж байна. Хавсралт: 2 файл	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

							төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.1. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага зохицуулалтаар хангах							
8	“Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам” боловсруулж батлуулна.	журам	-	Журмын төслийг боловсруулж батлуулсан байна	Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/87 дугаар тушаалаар "Сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам" батлагдсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7229 дугаарт бүртгэсэн. Тус журмыг Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлсэн бөгөөд журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	“Сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг ГБХНХЯ-тай хамтран боловсруулна.	журам	-	Журмын төслийг холбогдох яамтай хамтран боловсруулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар батлах “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын төслийг холбогдох нэгж, яамны мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан. Журмын төслийн эхний хэлэлцүүлгийг холбогдох нэгж, яамны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

					мэргэжилтнүүдийг оролцуулан хийсэн. Дараагийн хэлэлцүүлгүүдийг хийж журмын төслийг сайжруулан 2025 оны сүүлийн хагас жилд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт: 1 файл	р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	“MNS 5418:2008 Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага” стандартын төслийг шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын төсөл боловсруулалтын хувь	MNS 5418:2008 Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага	Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын төсөлд тусгах санал боловсруулсан байна.	Боловсролын сайдын 2024 оны А/214 дүгээр тушаалаар "Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага" стандартыг төслийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шинэчлэн боловсруулж танилцуулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд үүрэг болгосон. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн ажлын хэсэг байгуулан стандартын төслийг шинэчлэн боловсруулж эхний шатны хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2025 оны 5 дугаар сард стандартын төслийн хэлэлцүүлэгт оролцон саналаа хүргүүлсэн. Мөн тус стандартын төсөлд тусгах саналыг боловсруулан 2025 оны 1 дүгээр сард Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлсэн /саналыг хавсаргав/. Ажлын хэсгийн ахлагчтай холбогдож шаардлагатай бичиг баримт, саналаа хүргүүлэн хамтран ажиллаж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	“MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн	зөвлөмж	-	Стандартын хэрэгжилтэд хийсэн сургуулийн	2024 оны 11 дүгээр сард “MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд тулгуурлан сургалтын орчныг аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулна.			өөрийн үнэлгээ, хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийсэн байна.	хэрэгжилтэд ерөнхий боловсролын 882 сургууль өөрийн үнэлгээ хийсэн. 2024 оны 8-9 дүгээр сард Салбарын хяналтын газрын боловсрол, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнсний чанар, стандартын хяналт, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хичээлийн шинэ жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 635 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан. Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар 2024 оны 2-10 дугаар сард боловсролын сургалтын байгууллагын “хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэл”-ээр хяналт шалгалт хийж 153 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан. “MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын хэрэгжилтэд хийсэн ерөнхий боловсролын сургуулиудын өөрийн үнэлгээ болон дээрх хяналт шалгалтын тайланд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны аюулгүй байдалд шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан.	10-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
12	Суралцагчийн дүрэмт хувцасны стандартыг шинэчлэх чиглэлээр	Судалгаа, санал боловсруулсан хувь	MNS 6814:2019 сурагчийн дүрэмт хувцас,	Судалгаа хийсэн байна.	Боловсролын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг MNS6814:2019 “Сурагчийн дүрэмт хувцас. Техникийн шаардлага”	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын

	судалгаа хийж, санал боловсруулна.		техникийн шаардлага стандарт		стандартад өөрчлөлт оруулах эсэх, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн дүрэмт хувцасны нэр төрөлд поло загварын ханцуйтай цамц оруулах, суралцагчийн дүрэмт хувцасны чанар, эдэлгээ, загвар, хийц, нэр төрөл, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар судалгаа хийхээр судалгааны төслийг боловсруулсан. Судалгааг хийхэд шаардагдах 26.2 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй. Судалгааг хот, аймгийн төв, сумдын сургуулиудаас сонгон хоёр сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн. Ажлын хэсэг хоёр удаа хуралдаж дүрэмт хувцасны талаар хийсэн бусад судалгаа, олон улсын туршлагаас хуваалцсан. Хавсралт: 1 файл	сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
3.1. Ерөнхий боловсролын салбарын урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах							
13	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэнэ.	Ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	2024 онд цахим хуудсанд байршсан мэдээлэл	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.	Засгийн газрын 1111 төвөөр дамжиж ирсэн болон бусад хэлбэрээр ирүүлсэн 8 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь хүргүүлсэн. Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн 50 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь албан бичгээр хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

							гүйцэтгэсэн байдал: 100%
14	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн ил тод байдал	2024 онд байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан байна.	1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 96 дугаар тогтоолын хэрэгжитийг хангах хүрээнд тус тогтоолын хавсралтын 118-д заасан, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан ерөнхий боловсролын 32 сургуулийн мэдээллийг шил ажиллагаа буюу www.shilen.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. 2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 96 дугаар тогтоолын хэрэгжитийг хангах хүрээнд тус тогтоолын хавсралтын 117-д заасан, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын хөрөнгө оруулалттай-8, олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан-32, их сургуулийн дээд сургуулийн харьяа ахлах сургууль-19, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан хамтарсан сургууль-2, нийт 61 сургуулийн мэдээллийг Зөвшөөрлийн цахим систем буюу www.license.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. 3.Боловсролын яамны цахим хуудас www.moe.gov.mn-ны ил тод цэсний тусгай зөвшөөрөл хэсэгт Боловсролын асуудал эрхэлсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон 61 сургуулийн мэдээллийг нээлттэй байршуулсан. Холбоос: 1. https://shilen.gov.mn/open-data/detail?id=67d2acc31d64fc1c2c27fbcb 2. https://license.mn/licensed-organizations/tabs 3.https://moe.gov.mn/il-tod Хавсралт: 4 файл		
15	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж тайлагнана.	Хууль тогтоомж, шийдвэрийн тайланг хугацаанд нь батлуулж тайлагнасан эсэх	2024 онд хууль тогтоомж, шийдвэрийн тайланг хугацаанд нь батлуулж тайлагнасан	Хууль тогтоомж, шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хугацаанд нь чанартай тайлагнасан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан. Байгууллагын архивт 8 хадгаламжийн нэгжийг хүлээлгэж өглөө. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бусад байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн тайлан, мэдээллийг хугацаанд нь чанартай тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субьект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын яам болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана.	Боловсролын яам болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарт хамрагдана.	Байгууллагын мэдээллийн цаг, мэргэжил дээшлүүлэх сургалтад бүрэн хамрагдсан.	Мэргэжил дээшлүүлэх сургалт, байгууллагын мэдээллийн цагт хамрагдсан байна.	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт бүрэн хамрагдсан. Data school-ийн "Power BI Дашбоард", "Бизнес EXCEL 1.0" онлайн сургалтад хамрагдсан. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалсан.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнтэй холбоотой батлагдаж мөрдөгдөж байсан тушаал, шийдвэрүүд, шинээр батлагдсан боловсролын салбартай холбоотой Засгийн газрын тогтоол, дүрэм журмуудыг уншиж судлан бичиг баримт боловсруулахад ашиглалаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг зохиох, хэвлэх, түгээхтэй холбоотой олон улс (10 гаруй)-ын туршлагыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					судалсан.		

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дорж-Янжмаа Соёлмаа
/...../ Огноо: .....